Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн "Дотоод хяналт, шалгалтын комиссыг шинэчлэн батлах тухай" А/04 тушаалаар томилж Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар төлөвлөн улирлаар хяналт шалгалтыг хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар 2013 онд батлагдсан 4 бүлэг 71 зүйлтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,918.3 мянган төгрөгөөр буюу 8,2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>		2,000.0	2,000.0
<b>Авлага</b>	265.9	80,000.0	79,734.1
<b>Бараа материал</b>	77,805.9	85,084.2	7,278.3
<b>Үндсэн хөрөнгө</b>	848,134.5	835,040.6	-13,093.9
Нийт хөрөнгө	<b>926,206.4</b>	<b>1,002,124.7</b>	75,918.3
<b>Өр төлбөр</b>	1,150.0	0	-1,150.0
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	925,056.4	1,002,124.7	77,068.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>926,206.4</b>	<b>1,002,124.7</b>	<b>75,918.3</b>

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл

2,000.0 мянган төгрөг байна. Энэ нь ЗДТГ-ын ХААН банкин дахь арилжааны 5744069324 тоот дансанд 2023 оны 7 дугаар сарын 09-нд Тэргүүн-Оюун ХХК-аас соёолон насны морь байны шагналд тушаасан хандиваас шалтгаалжээ.

Авлага дансны эхний үлдэгдэл 265.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 80,000.0 мянган төгрөг буюу төрийн албан хаагчийн орон сууц хүлээн аваагүй 79,734.1 мянган төгрөгийн авлагаар нэмэгдсэн байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 77,805.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 85,084.2 мянган төгрөг буюу 57,672.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 46,784.7 мянган төгрөгөөр хагсагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 926,206.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,002,124.7 мянган төгрөг, 75,918.3 мянган төгрөгөөр буюу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийсэн хөрөнгө нэмэгдэж, 35,155.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 53.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлснээс шалтгаалжээ.

Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/141 тоот захирамжаар 136,681.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 32,300.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 19,338.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжийн сангийн хөрөнгөөр үнэ төлбөргүй 69,200.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 9,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1,150.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг буюу 1,150.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,002,124.7 мянган төгрөг болж 77,068.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 493,986.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 50,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 498,986.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 45,000.0 мянган төгрөгөөр нийт 543,986.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг Төв аймгийн Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор, 44,441.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 588,427.2 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 587,427.2 мянган төгрөгийн санхүүжилт, хандив тусламжийн орлого 2,000.0 мянган төгрөгийг нийт 589,427.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,904.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага тайлант онд орон нутгийн төсвийн орлого бүрдээгүйгээс 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож, хандиваар ирсэн 2,000.0 мянган төгрөг арилжааны банканд зарцуулаагүй үлдэгдлээр байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 580,522.6 мянган төгрөг буюу 98,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 6,904.5 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	380,906.6	374,002.1	6,904.5	98.2
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	47,423.7	47,423.7	0.0	100.0
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	30,461.2	30,461.2	0.0	100.0
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал	12,881.3	11,881.3	1,000.0	92.2
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- бусад	100,989.4	100,989.4	0.0	100.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- орон нутгийн нөөц хөрөнгө зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- улсын баяр наадмын зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	765.0	765.0	0.0	100.0
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
	<b>Дүн</b>	588,427.2	580,522.7	7,904.5	98.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн нэмэгдэлд 40,761.3 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 1,053.9 мянган төгрөг, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах ажлын эцсийн санхүүжилт 100,000.0 мянган төгрөг, барьцаа сангийн төлбөр 3,976.9 мянган төгрөг, төсвийн хүрээнд бий болсон орлого 1,583.8 мянган төгрөг нийт 147,375.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт дансаар орон нутгийн нэмэгдэлд 40,761.3 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 1,053.9

мянган төгрөг, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах ажлын эцсийн санхүүжилт 80,000.0 мянган төгрөг, төсвийн хүрээнд бий болсон орлого 1,583.8 мянган төгрөг нийт 123,399.0 мянган төгрөгийн зарцуулж, 23,976.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж үүнээс 3,976.9 барьцаа сангийн мөнгө, 20,000.0 мянган төгрөгийн төрийн албан хаагчийн орон сууцны санхүүжилтийн үлдэгдэл байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 99.4%	582,662.2	574,757.7
2	71411- Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	5,765.0	5,765.0
<b>Дүн</b>					<b>588,427.2</b>	<b>580,522.7</b>

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сүмбэр сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 196,019.5 мянган төгрөгөөр бичиг хэрэг, шатахуун, эд хогшил, шуудан холбооны зардлыг шууд худалдан авалтаар, хүүхдийн тоглоомын талбай, ахуй үйлчилгээний засварын 64,700.0 мянган төгрөгөөр харьцуулалтаар тендер зарлахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 46,469.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авалтаар, 64,700.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг харьцуулалтаар тендер зарлаж худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шатахууны тооцоо бодолтой холбоотой зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын ИТХ-аас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан 2023 оны төсвийн 544,437.9 мянган төгрөгийн нийт зардлын 1,0 хувиар буюу 5,444.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,083.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100%-тай, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл 1, 5,0 саяас дээших орлогын 12 гүйлгээ, зарлагын 12 гүйлгээг мэдээлснээс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл 2 байршуулж, хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж өгсөн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 1 төлбөрийн акт, хандив тусламж, төсвийн зарцуулалттай холбоотой 2 албан шаардлага, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 06/17 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,472.7	1	1,472.7	100
Албан шаардлага	1	46,351.5	1	46,351.5	100
Зөвлөмж	1	159,843.6	1	159,843.6	100
Нийт дүн	3	207,667.9	1	207,667.9	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 736,359.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 736,359.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Тус байгууллага тайлант оны санхүүгийн байдлын тайланд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгөөр тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайлан дахь орон нутгаас болон дээд шатны захирагчаас авсан санхүүжилтийг бөөн дүнгээр 734,359.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 57,116.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 10,647.6 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 46,469.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1.Тайлант онд тус байгууллагын ХААН банкин дахь арилжааны 5744069324 тоот дансанд 2023 оны 7 дугаар сарын 09-нд Тэргүүн-Оюун ХХК-аас соёолон насны морьт байны шагналд 2,000.0 мянган төгрөгийн хандивын үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 5 дугаар зүйлийн 5.5-д “Төлбөрийн картан дансыг өөрийн орлогыг төвлөрүүлэх, дамжсан гүйлгээ хийх зэрэг төрийн сангаас санхүүжилт авахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” захирамж, Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл шинэчлэн тогтоож орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/01 захирамжаар Улс төрийн 4 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 8,008.8 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

1.Тус байгууллага тайлант онд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” Б/30 тоот Засаг даргын захирамжаар Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө 40% буюу 638.8 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.4 Зөвлөмж**

### 2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд аж ахуй нэгж байгууллагаас 46,469.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус худалдан авсан байна.Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”.гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрийн бараанаас худалдан авалт хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тус байгууллага тайлант оны санхүүгийн байдлын тайланд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлагнаагүй байна	1	2,000.0	1	2,000.0			1
Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайлан дахь орон нутгаас болон дээд шатны захирагчаас авсан санхүүжилтийг бөөн дүнгээр зөрүүтэй тайлагнасан байна.	1	734,359.2			1	734,359.2	1	734,359.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>736,359.2</b>	<b>1</b>	<b>2,000.0</b>	<b>1</b>	<b>734,359.2</b>	<b>1</b>	<b>736,359.2</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХААН банкин дахь арилжааны 5744069324 тоот дансанд хандив хийснээс үлдэгдэлтэй гарсан байна	1	2,000.0	1	2,000.0				
Улс төрийн 4 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл олгосон зөрчил илэрлээ	1	8,008.8	1	8,008.8				
Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө 40% буюу илүү авсан байна	1	638.8	1	638.8				
Аж ахуй нэгж байгууллагаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус худалдан авсан байна	1	46,469.0					1	46,469.0
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>57,116.6</b>	<b>3</b>	<b>10,647.6</b>			<b>1</b>	<b>46,469.0</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)